

Centre for Law and Democracy
info@law-democracy.org
+1 902 431-3688
www.law-democracy.org
fb.com/CentreForLawAndDemocracy
[@Law_Democracy](https://twitter.com/Law_Democracy)

ГҮТГЭЛЭГ

Хэвлэл мэдээллийн ихэнх хуульч өөрийн орны хуулийн тогтолцоон дахь гүтгэлгийн хуулийн талаар зохих мэдлэгтэй байдаг. Гэвч тэд энэ чиглэлийн олон улсын стандартыг сайн мэдэхгүй байж магадгүй юм. Энэхүү өндөр хөгжсөн стандарт нь гүтгэлгийн тухай хуулийг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хүндлэх, үүний зэрэгцээгээр хүний нэр хүндийг зохих ёсоор хамгаалах баталгаа болгох тал дээр чухал удирдамж болдог.

Гүтгэлтэд үндэслэсэн аливаа хууль эрх зүйн хязгаарлалт нь бусдын нэр хүндийг хамгаалах зорилго агуулах ёстой бөгөөд энэ нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах гурван хэсэгт шалгуурын хоёр дахь хэсгийн хууль ёсны зорилго юм. Гэвч гүтгэлгийн эсрэг зарим хуулийг боловсруулахдаа “хуульд заасан байх” тухай шаардлагыг хангах хэмжээний нарийвчлалыг хангаагүй, үгүй бол хүний нэр төрийг хамгаалах шаардлагатай болон зохистой байдлаас хэтэрсэн байна. Энэ бүлэгт эхлээд зохистой шийтгэл болон гүтгэлгийн эсрэг эрүүгийн хуулийн тухай авч үзээд дараа нь гүтгэлтэй холбоотой иргэний хэрэг дээр үүсдэг нэг хэсэг асуудлын талаар хэлэлцэнэ. Дараагийн хэсэг төрийн албан тушаалтан, улс төрчдийн эсрэг үүсгэсэн гүтгэлгийн шинжтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой бөгөөд эцэст нь олон нийтийн бодлогын эсрэг стратегийн нэхэмжлэлээр (SLAPP-strategic litigation against public policy) гүтгэлгийн тухай хуулийг урвуудан ашиглахыг хязгаарлах зорилготой хуулиудыг тоймлон авч үзнэ.

Хуулийн өөр өөр тогтолцоонд доромжлох, нэр хүнд гутаах, гүтгэх гэх мэт гэмт хэргүүдийг хооронд нь ялгаж тогтоож болох тул гүтгэлэг гэдэгт бид нэр төртэй холбоотой гэмт хэргийг ерөнхийд нь хамааруулна гэдгийг анхаарна уу.

Эрүүгийн шийтгэл ба зохистой бус шийтгэл

Гүтгэлгийн тухай эрүүгийн хуулиуд, ялангуяа хорих ялаар шийтгэх заалттай хууль нь олон улсын хүний эрхийн хуульд нийцдэггүй. Гүтгэсний шийтгэл болгон хорих ял оноох нь хэзээд зохистой шийтгэл биш юм. Учир нь хүний эрх чөлөөг хязгаарлах нь хатуу шийтгэл бөгөөд үүнээс бага хэмжээгээр залхаах иргэний эрхийг хамгаалах хэрэгсэл ч хүний нэр хүндийг зохих ёсоор хамгаалдаг. Цаашилбал, хорих шийтгэл нь үгээ хэлэхийг хязгаарлах, мөн олон нийтийн ашиг сонирхлын асуудлаарх мэтгэлцээнийг дарах ноцтой эрсдэлийг бий болгодог.

Олон улсын хүний эрхийн байгууллагууд энэ стандартыг улам бүр хүлээн зөвшөөрч, гүтгэлгийг эрүүгийн хуулиар шийдвэрлэж ял эдлүүлэх нь үзэл бодлоо чөлөөтэй

илэрхийлэх эрхийг зөрчиж байна гэж үзжээ. Тухайлбал, Хүний эрхийн хороо 34-р ерөнхий саналдаа, улс орнуудыг гүтгэлгийн хэргийг гэмт хэрэг гэж үзэхгүй байхыг уриалж, эрүүгийн хууль зөвхөн “хамгийн хүнд тохиолдолд” үйлчлэх ёстой бөгөөд “хорих ял бол хэзээд зохистой шийтгэл биш” гэж тэмдэглэжээ.⁵⁰ Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний талаарх олон улсын тусгай мандат зэрэг бусад олон эрх мэдэл бүхий мэдэгдэлд хорих ял нь зохистой шийтгэл биш гэдгийг нотолсон ба/эсвэл гүтгэлгийг эрүүгийн хуулиар шийдвэрлэх явдлыг бүхэлд нь халахыг уриалсан.⁵¹

Африкийн Хүний болон Ард түмний эрхийн шүүх гүтгэлгийн төлөө шоронд хорих нь зохистой шийтгэл биш гэдгийг тодорхой баталсан (доорх хайрцгийг харна уу). Энэхүү чухал шийдвэрийн дараа Баруун Африкийн улсуудын эдийн засгийн нийгэмлэгийн шүүх⁵² болон Зүүн Африкийн шүүхээс ижил төстэй шийдвэр гаргасан.⁵³ Америк хоорондын болон Европын хүний эрхийн шүүхүүд энэ стандартыг ийм тодорхой батлаагүй байна. Энэ хоёр шүүх хоёулаа гүтгэлгийн хэргийг эрүүгийн гэмт хэрэг гэж үзэж торгууль⁵⁴, эсвэл хэдэн сарын хорих ялыг тэнсэн харгалзах шийтгэл оноодог.⁵⁵ Гэвч аль аль нь хорих ялыг хэзээд зохистой шийтгэл биш гэж шууд мэдэгдээгүй ч хоёулаа гүтгэлгийн хэрэгт оноох эрүүгийн шийтгэлд хатуу хязгаарлалт тогтоож, шийтгэлийг онцгой тохиолдолд л хэрэглэх ёстой гэж мэдэгджээ. Хоёр шүүх гүтгэлгийн хэрэгт хорих ял ногдуулах нь зохистой шийтгэл биш болохыг тогтоосоор ирсэн, энэ нь ялангуяа нийтийн ашиг сонирхол, мэтгэлцээнтэй холбоотой үг хэлсэн тохиолдолд бүр ч хамаатай юм.⁵⁶ Европын Хүний эрхийн Их Танхим хэвлэл мэдээллийн хэрэгслээр гэмт хэрэг үйлдсэний төлөө хорих ялыг "онцгой нөхцөл байдалд, ялангуяа бусад үндсэн эрх ноцтойгоор хохирсон тохиолдолд, тухайлбал үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэг, хүчирхийллийг өдөөн турхирсан тохиолдолд" оноох ёстой гэж мэдэгджээ.⁵⁷ Ерөнхийдөө, тэдний хууль тогтоомжоор гүтгэлгийн хэрэгт эрүүгийн хариуцлагыг маш

⁵⁰ General Comment No. 34, note 43, para. 47.

⁵¹ See, for example, special international mandates on freedom of expression, 2002 Joint Declaration, <https://bit.ly/3DHYj37>; 2010 Joint Declaration, Tenth Anniversary Joint Declaration: Ten Key Challenges to Freedom of Expression in the Next Decade, <https://bit.ly/3Uf9lmy>; Declaration of Principles on Freedom of Expression and Access to Information in Africa, note 16, Principle 22(4); Parliamentary Assembly of the Council of Europe, Resolution 1577(2007), and Towards Decriminalisation of Defamation, Resolution 1577 (2007), 4 October 2007, para. 17.1, <https://bit.ly/3T5gSUI>; African Commission on Human and Peoples' Rights, 169 Resolution on Repealing Criminal Defamation Laws in Africa, ACHPR/Res.169(XLVIII)10, 24 November 2010, <https://bit.ly/3Urm2ve>.

⁵² *FAJ and Others v. The Gambia*, 13 March 2018, No. ECW/CCJ/APP/36/15, pg. 47, <https://bit.ly/3TgrW13>.

⁵³ *Media Council of Tanzania and Ors. v. Attorney General of Tanzania*, 28 March 2019, No. 2 of 2017, para. 91, <https://bit.ly/3TjyI6A>.

⁵⁴ See, for example, *Lindon, Otchakovsky-Laurens and July v. France*, 22 October 2007, Applications Nos. 21279/02 and 36448/02 (European Court of Human Rights), <https://bit.ly/3NNmHF9>; and *Bédat v. Switzerland*, 29 March 2016, Application No. 56925/08 (European Court of Human Rights), <https://bit.ly/3Udg953>.

⁵⁵ *Memoli v. Argentina*, 22 August 2013, Series C, No. 265 (Inter-American Court of Human Rights), <https://bit.ly/3zLTXXK>.

⁵⁶ See, for example, *Kimel v. Argentina*, 2 May 2008, Series C, No. 177, para. 85 (Inter-American Court of Human Rights), <https://bit.ly/3zObzCd>; *Castells v. Spain*, 23 April 1992, Application No. 11798/85, para. 48 (European Court of Human Rights), <https://bit.ly/3t1XBIJ>.

⁵⁷ *Cumpănă and Mazăre v. Romania*, 17 December 2004, Application No. 33348/96, para. 115, <https://bit.ly/3fCwBNa>.

хязгаарлагдмал ангиллын хэрэгт хүлээлгэх ёстой гэж үздэг бөгөөд хорих ялын тухайд бол, ер нь оноох юм бол маш ховор тохиолдолд л оноох юм.

*Лохе Исса Конатэ Буркина Фасогийн эсрэг,
Африкийн хүний болон ард түмний эрхийн шүүх*

Сэтгүүлч, сонины редактор улсын яллагчийг ёс бус үйлдэл гаргасан хэмээн буруутгасан нийтлэлүүд гаргажээ Үүний хариуд прокурор өөрийг нь гүтгэсэн, олон нийтэд доромжилсон, шүүхийг үл хүндэлсэн гэх үндэслэлээр редакторын эсрэг гомдол гаргасан байна. Шүүхээс 12 сар хорих ял, торгууль, мөн бусад зардлыг барагдуулах ял оноож, сонины үйл ажиллагааг зургаан сараар түдгэлзүүлэх шийдвэр гаргажээ.⁵⁸

Африкийн хүний болон ард түмний эрхийн шүүхээс ялыг үндэслэсэн мэдээллийн хууль болон эрүүгийн хуулийн заалтуудыг нягталж үзсэн. Шүүхээс уг заалтууд бусдын нэр хүндийг хамгаалах хууль ёсны зорилготой гэдгийг хүлээн зөвшөөрсөн боловч зайлшгүй шаардлага болон зохистой байдлын шаардлагыг хангаагүй гэж үзжээ. Нарийвчилбал, хорих ялыг зохистой ял гэж үзээгүй бөгөөд шүүхээс “гүтгэлэгтэй холбоотой аливаа хорих ял нь Дүрэмд (Charter) нийцэхгүй байна” гэж баталсан.⁵⁹ Цаашилбал, бусад эрүүгийн хариуцлага (торгууль гэх мэт) ч зохистой байх ёстой. Энэ тохиолдолд Буркина Фасо сэтгүүлчдэд оноосон торгууль, зардал, эсвэл сонины үйл ажиллагааг зургаан сараар түдгэлзүүлэх нь прокурорын нэр хүндийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай гэдгийг нотлоогүй.⁶⁰ Түүнчлэн, зардал нь редакторын "орлогоос үлэмж хэтэрнэ" гэдгийг нотлоогүй, ялангуяа сонины үйл ажиллагааг зургаан сарын хугацаанд зогсоосноор орлого алдахыг харгалзан үзэх хэрэгтэй.⁶¹

⁵⁸ *Lohé Issa Konaté v. Burkina Faso*, 5 December 2014, Application No. 004/2013, paras. 5-6, <https://bit.ly/3fCy8CU>.

⁵⁹ *Ibid.*, para. 167.

⁶⁰ *Ibid.*, paras. 165-166 and 169.

⁶¹ *Ibid.*, para. 171.

Хорих ял хэзээ ч зохистой шийтгэл байж чаддаггүй, гэвч үүний зэрэгцээгээр бусад төрлийн эрүүгийн шийтгэл, жишээлбэл хэт их торгууль ногдуулах, сэтгүүд зүйн үйл ажиллагаа эрхлэхийг хориглох, иргэний эрхийг хасах зэрэг дээр ч зохистой байдлын асуудал үүсдэг.⁶² Туйлын зорилго бол улс орнууд гүтгэлгийг эрүүгийн гэмт хэргээс бүр мөсөн хасах тухай авч үзэх ёстой бөгөөд, хүний нэр төрд учруулсан хохирлыг шийдэхэд иргэний эрх зүйн хэрэгслийг ашиглах нь зүйтэй юм.⁶³ Шийтгэл өөрөө уг чанартаа эрүүгийн шинжтэй байдаг нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг илүү ноцтойгоор хязгаарлаж, улмаар зохистой бус байх магадлал илүү юм. Жишээлбэл, Америк хоорондын хүний эрхийн шүүх *Кимел Аргентины эсрэг* шүүх хуралд шүүгчийн зан үйлийг шүүмжилсэн үг хэлснийх нь төлөө эрүүгийн торгууль ногдуулах (мөн хорих ялыг тэнсэн харгалзах ял) оногдуулах нь зохистой шийтгэл биш гэж үзсэн байдаг. “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” өөрөө, мөн гэмт хэрэгтний бүртгэлд орсон, эрүүгийн ял авсан гутамшиг зэрэг нь бүгд шийтгэлийн зохистой бус байдалд нөлөөлсөн ба үүн дээр торгуулийн жинг бас нэмэх хэрэгтэй.⁶⁴ Үүний нэгэн адил Европын Хүний эрхийн шүүх гүтгэлгийн гэмт хэрэгт эрүүгийн торгууль ногдуулахыг хүлээн зөвшөөрсөн ч зайлшгүй шаардлага болон зохистой байдлыг үнэлэхэд торгуулийн эрүүгийн шинж чанар нь холбогдох хүчин зүйл болно гэж үздэг.⁶⁵

Гүтгэлгийг эрүүгийн хуулиар шийдэхээс ялгаатай нь иргэний хуулиар шийдвэрлэж шийтгэл хүлээлгэхэд зохистой бус байх эрсдэл бага юм. Гэвч иргэний нэхэмжлэлд хэт өндөр мөнгөн дүнтэй хохирол барагдуулах нь зохистой биш байж болох ба үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд муугаар нөлөөлж болзошгүй.⁶⁶ Иймээс улс орнууд хохирлын дээд хэмжээг тогтоох эсвэл бодит хохиролтой харьцуулшгүй өндөр нөхөн төлбөрөөс урьдчилан сэргийлэх бусад арга хэмжээг авах талаар авч үзэх ёстой. Утас хууль бусаар чагнасан гэж Ерөнхий прокурорыг буруутгасан хуульчаас "иргэний хуулиар маш их хэмжээний нөхөн төлбөр" нэхэмжилсэн хэргийн улмаас Америк хоорондын хүний эрхийн шүүх иргэний хуулиар их хэмжээний хохирлыг барагдуулахтай холбоотой асуудлыг тайлбарласан:

⁶² 2010 Joint Declaration, Tenth Anniversary Joint Declaration: Ten Key Challenges to Freedom of Expression in the Next Decade, note 51, para. 2(g).

⁶³ General Comment No. 34, note 43, para. 47; special international mandates on freedom of expression, 2000 Joint Declaration, 30 November 2000, <https://bit.ly/3E8shim>.

⁶⁴ *Kimel v. Argentina*, note 56, para. 85. See also *Usón-Ramírez v. Venezuela*, 20 November 2009, Series C, No. 2017, para. 81, <https://bit.ly/3NFJUcg>.

⁶⁵ See, for example, *Tête v. France*, 26 March 2020, Application No. 59636/16, para. 68, <https://bit.ly/3FLnvsd>; and *Affaire Lacroix v. France*, 7 September 2017, Application No. 41519/12, para. 50, <https://bit.ly/3FPDdT3>.

⁶⁶ 2021 Joint Declaration on Politicians and Public Officials and Freedom of Expression, note 35, para. 2(b)(iv)(b); and Declaration of Principles on Freedom of Expression and Access to Information in Africa, note 16, Principle 22(3).

Мөнгөн торгуулийн айдас. . . ямар ч тохиолдолд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэрэгжүүлэхэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхтэй адил буюу түүнээс илүү айдас төрүүлж, саад болж мэдэх юм. Энэ айдас нь төрийн албан тушаалтныг буруутгаж буй хувь хүний хувийн болон гэр бүлийн амьдралд орж ирснээр хохирсон тал болон төрийн албан тушаалтны үйлдлийг шүүмжилдэг бусад хүмүүсийн аль алинд нь өөрийгөө хянаж цензүрдэх мэдээжийн, маш сөрөг үр дүнд хүргэж болно.⁶⁷

Гүтгэлгийг иргэний хуулиар шийдвэрлэх

Гүтгэлгийн хэргийг шийдвэрлэдэг иргэний хууль болон шүүхийн шийдвэр ч үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчих тохиолдол байдаг. Гэвч энд, гүтгэлгийн эсрэг эрүүгийн хуульд хамаардгаас ч илүүтэйгээр шийтгэлийн зохистой байдлын нарийн дүн шинжилгээ хийх хэрэгтэй. Энэ нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зүй бусаар хязгаарлахаас урьдчилан сэргийлэх зорилготой юм. Гэвч гүтгэлгийн эсрэг иргэний хуулиар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зүй бусаар хязгаарлахаас урьдчилан сэргийлэхэд зайлшгүй шаардлагатай хэд хэдэн үндсэн хамгаалалтыг олон улсын жишигт тодорхойлсон байдаг. Тэдгээрийг энд товч тоймлов.

Үнэнийг хэлсний төлөө гүтгэлгийн хуулиар шийтгэж болохгүй.⁶⁸ Иймээс гүтгэлгийн хэрэгт буруутгагдсан хүнд хэзээ ч үнэн өөрийг нь хамгаална гэсэн итгэл найдвар байх ёстой, эсвэл, эсрэгээрээ нэхэмжлэгчээс худал гэдгийг нотлохыг шаардаж болно. Энэхүү хамгаалалт нь нийтлэг хууль болон иргэний эрх зүйн аль алинд нь байдаг уламжлалтай боловч тэр бүр нэгдмэл ойлголт илэрхийлдэггүй. Олон улсын жишгээр гүтгэлэгтэй холбоотой бүхий л хэрэгт ийм хамгаалалт байлгахыг шаарддаг.⁶⁹ Нэхэмжлэлийн худал болохыг нотлох үүргийг нэхэмжлэгчид шилжүүлэх нь хуулийн өөр нэг арга зам юм. Олон улсын стандартаар гүтгэлгийн шинжтэй мэдэгдэл нь олон нийтийн анхаарлыг татсан асуудалтай холбоотой тохиолдолд ийм арга замыг улам бүр шаарддаг.⁷⁰ Ийм үед нотлох үүргийг нэхэмжлэгчид шилжүүлэх нь олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн асуудлаарх мэтгэлцээнийг нээлттэй байлгахад тустай бөгөөд нийгмийн зүтгэлтний нэр холбогдсон гүтгэлгийн олон маргаанд угийн эрх мэдлийн тэнцвэргүй байдал байдгийг хүлээн зөвшөөрч байна.

Гүтгэлгийн тухай хуулиар үзэл бодолд шийтгэл оноох ёсгүй, үзэл бодол бол ут

⁶⁷ *Tristán Donoso v. Panama*, 27 January 2009, Series C, No. 193, para. 129, <https://bit.ly/3E6CWd9>.

⁶⁸ General Comment No. 34, note 43, para. 47; and Declaration of Principles on Freedom of Expression and Access to Information in Africa, note 16, Principle 21(1)(a).

⁶⁹ See *Rafael Marques de Morais v. Angola*, 18 April 2005, Communication No. 1128/2002, para. 6.8 (Human Rights Committee); *Castells v. Spain*, note 56, para. 48; and *Colombani and Ors v. France*, 25 June 2002, Application No. 51279/99, para. 66 (European Court of Human Rights).

⁷⁰ 2000 Joint Declaration, note 63; and Report of the Special Rapporteur on the promotion and protection of the right to freedom of opinion and expression, Mission to Italy from 11 to 18 November 2013, 29 April 2014, para. 23, <https://undocs.org/A/HRC/26/30/Add.3>. See also the discussion of actual malice below.

чанараараа шалгах боломжгүй зүйл юм.⁷¹ Европын хүний эрхийн шүүхээс тэмдэглэснээр “баримт ба хувь хүний дүгнэлтийг (value-judgments) сайтар ялгах хэрэгтэй. Баримт байгаа эсэхийг нотлох боломжтой, харин хувь хүний дүгнэлтийг үнэн эсэхийг нотлох аргагүй юм.”⁷² Үүний адилаар Америк хоорондын хүний эрхийн шүүх “хүний санаа бодолд шийтгэл оноох боломжгүй” гэж тэмдэглэсэн байдаг.⁷³

Мэдэгдэл худал байсан ч мэдэгдлийн эзэн хатуу хариуцлага хүлээх ёсгүй, ядаж л энэ мэдэгдэл нь олон нийтийн ашиг сонирхлын талаарх маргааны нэг хэсэг бол. Хатуу хариуцлага хүлээлгэх нь шударга алдаанд хангалттай хамгаалалт болж чадахгүй. Жишээлбэл, хичээнгүй сэтгүүлч ч алдаа мадагтай мэдэгдэл хийх үе байдаг, ялангуяа найдвартай эх сурвалж олоход хэцүү, эмзэг асуудлаар мэдээлэл хийх үед алдаа гаргах боломжтой. Иймээс "үндэслэлтэй нийтлэл"-ийг өмгөөлөх хамгаалалт бэлэн байх ёстой юм. Энэ хамгаалалтыг тухайн нөхцөл байдалд тэр мэдэгдлийг хийх үндэслэл байсан тохиолдолд хэрэглэнэ.⁷⁴ Эсвэл ижил төстэй хамгаалах хэрэгсэл нь ижил төстэй хамгаалалтыг хангаж болно, тухайлбал илтгэгч сайн санааны үйл хийсэн гэх мэт. Сэтгүүлчдийн хувьд үндэслэлтэй байдлыг сэтгүүлчийн ёс зүйн стандартын дагуу тогтоож болох юм. Энэ асуудалд Европын хүний эрхийн шүүх хэрхэн хандсан талаарх жишээг доор гаргалаа.

⁷¹ General Comment No. 34, note 43, para. 47; and 2000 Joint Declaration, note 63.

⁷² *Lingens v. Austria*, 8 July 1986, Application No. 9815/82, para. 46, <https://bit.ly/3TbPGnf> (cited to in subsequent cases such as *Dichand and Ors v. Austria*, 26 February 2002, Application No. 29271/95, para. 42; and *Dalban v. Romania*, 28 September 1999, Application No. 28114/95, para. 49)

⁷³ *Kimel v. Argentina*, note 56, para. 93;. See also *Usón-Ramírez v. Venezuela*, note 64, para. 86.

⁷⁴ See, for example, 2021 Joint Declaration on Politicians and Public Officials and Freedom of Expression, note 35; 2000 Joint Declaration, note 63; and Declaration of Principles on Freedom of Expression and Access to Information in Africa, note 16, Principle 21(1)(a).

Европын хүний эрхийн шүүх, *Тромсё ба Стенсаас Норвегийн эсрэг*

Норвегийн нэгэн сонин болон түүний редакторыг далайн хав агнуурын тухай нийтлэл бичиж, түүндээ агнуурын хууль бус, харгис хэрцгий арга хэрэглэсэн талаар мэдээлсэн тул гүтгэсэн хэргээр шийтгэжээ. Нийтлэлийг байцаагчийн бичсэн, зарим талаараа маргаантай тайланд үндэслэн бичсэн байсан бөгөөд цаашдын мөрдөн байцаалтын явцад баримтын нэг хэсэг нь үндэслэлгүй байжээ.

Гүтгэлгийн хэрэгт оноосон ял үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчсөн эсэхийг үнэлэхдээ Европын шүүхийн Их танхим олон нийтийн хууль ёсны асуудлыг хэлэлцэхэд хэвлэл мэдээллийн оролцоог мохоож мэдэх ял шийтгэлд “хамгийн нарийн хяналт” тавих ёстой гэж тэмдэглэжээ.⁷⁵ Нөгөө талаар, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ч өөрийн гэсэн онцгой үүрэг, хариуцлага хүлээдэг бөгөөд үүнд бусдын нэр хүндийг хүндлэх үүрэг ч багтдаг. Энэ нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл гүтгэлгийн шинжтэй материалыг нягтлан шалгах ёстой гэсэн үг. Харин шүүх дараа нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл энэ үүргээ биелүүлэхээс татгалзах “онцгой үндэслэл” байгаа эсэхийг хэлэлцсэн.⁷⁶ Ийм онцгой үндэслэл байгаа эсэхийг үнэлэх нэг хүчин зүйл бол сонины газар байцаагчийн дүгнэлтийг найдвартай гэж үзэх нь үндэслэлтэй эсэх явдал юм. Шүүх, уг сонин байцаагчийн тайланг найдвартай гэж үзсэнийг үндэслэлтэй гэж тогтоосон бөгөөд “энэ тал дээр сонины газар үнэнч шударга ажилласан гэдэгт эргэлзэх шалтгаан байхгүй” гэж үзжээ.⁷⁷ Эцсийн дүндээ нэр хүндийн ашиг сонирхол нь “олон нийтийн мэтгэлцээнийг мэдээллээр хангах амин чухал олон нийтийн ашиг сонирхлоос” даваагүй бөгөөд шүүхээс гүтгэлгийн хэрэгт ял оноох шаардлага байгаагүй бөгөөд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчсөн байна гэж үзжээ.⁷⁸

⁷⁵ *Bladet Tromsø and Stensaas v. Norway*, 20 May 1999, Application No. 21980/93, para. 64, <https://bit.ly/3U9T3fR>.

⁷⁶ *Ibid.*, paras. 65-66.

⁷⁷ *Ibid.*, para. 72.

⁷⁸ *Ibid.*, para. 73.

"Үндэслэлтэй нийтлэл"-ийн хамгаалалтын зэрэгцээгээр, хүмүүс бусдын хийсэн мэдэгдлийг дамжуулсны төлөө шийтгэл хүлээх ёсгүй гэсэн зарчим үйлчлэх ба энэ зарчим наад зах нь бусдын хийсэн мэдэгдлийг найдвартай гэж үзэх үндэслэлтэй үед үйлчилнэ.⁷⁹ Сэтгүүлчид, ялангуяа ийм мэдэгдлийг тэр бүр нягтлах боломжгүй байдаг, гэтэл уг мэдээллийг сонирхох олон нийтийн сонирхол өндөр хэвээр байж болох юм. *Херрера Уллоа Коста Рикагийн эсрэг* шүүх хурлаар Америк хоорондын Хүний эрхийн шүүх гүтгэлгийн хэргээр эрүүгийн ял авсан сэтгүүлчийн хэргийг авч хэлэлцжээ. Уг сэтгүүлч Коста Рикагийн төрийн албан тушаалтны зан үйлийн талаар Бельги улсын мэдээнд гарсныг хэсэгчлэн дамжуулжээ. Шүүгч, шүүх хурлаараа уг сэтгүүлч Европын сонинуудад гарсан мэдээллийн үнэн зөвийг нотлоогүй тул түүнд хуулийн хариуцлага тооцсон. Америк хоорондын шүүх ийм нотлох стандарт нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг "хэт хязгаарласан" бөгөөд энэ нь сэтгүүл зүйн практикт "халшраах, айлгах, саад хийх" нөлөөтэй гэж үзсэн.⁸⁰ Хэлсэн үгийг бүр илүү хамгаалах арга бол "бодит хорон санаа" стандартыг хэрэгжүүлэх явдал юм (дараах хайрцагт тайлбарласан).

⁷⁹ See, for example, *Herrera Ulloa v. Costa Rica*, 2 July 2004, Series C, No. 107, paras. 132-133 (Inter-American Court of Human Rights), <https://bit.ly/3fLJfjL>; and *Thorgeir Thorgeirson v. Iceland*, 25 June 1992, Application No. 13778/88, para. 65 (European Court of Human Rights).

⁸⁰ *Herrera Ulloa v. Costa Rica*, note 79, paras. 132-133.



"Бодит хорон санаа" стандарт ба түүний хувилбарууд

"Бодит хорон санаа" стандартыг анх АНУ-ын Дээд шүүхийн түүхт хэрэг болох *Нью Йорк Таймс Салливаны эсрэг* маргаанд тодорхойлжээ.⁸¹ Шүүхээс, нийгмийн зүтгэлтэн нэр холбогдсон гүтгэлгийн хэрэгт "бодит хорон санаа" стандартыг хэрэглэх ёстой гэж үзсэн. Бодит хорон санаа гэдэг нь илтгэгч уг мэдэгдлийг худал гэдгийг мэдэж байсан, эсвэл худал хуурмаг байдлыг үл тоомсорлон үйлдэл хийсэн гэсэн үг юм. Нэхэмжлэгч бодит хорон санааг нотлох ёстой, ингэснээр хариуцагчаас мэдүүлгээ үнэн гэж нотлохыг шаарддаг нотолгооны уламжлалт дарамтыг сольж тавьсан хэрэг юм.

Бодит хорон санааны стандарт нь нэхэмжлэгчийн хувьд маш өндөр шалгуурыг тавьдаг тул энэ нь хэлсэн үгийн хамгаалалтыг өндөр түвшинд гүйцэтгэдэг. Үүнийг хүлээн зөвшөөрч, бусад улс ч мөн бодит хорон санааны стандарт, эсвэл түүний хувилбарыг баталсан.⁸² Нөгөө талаар, зарим улс үүнээс шууд татгалзаж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон нэр хүндийн эрхийн хооронд зохистой тэнцвэрийг бий болгохын тулд энэ хэсэгт авч үзсэн бусад стандартыг хослуулан хэрэглэж байна.⁸³

Америк хоорондын хүний эрхийн комиссоос баталсан Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зарчмын тухай Америк хоорондын тунхаглал нь нийтийн ашиг сонирхлын асуудалд сайн дураараа оролцож байгаа төрийн албан тушаалтан, нийгмийн зүтгэлтэн болон хувь хүмүүстэй холбоотой хэрэгт бодит хорон санааны стандартын хувилбарыг хэрэглэхийг уриалсан:

Эдгээр тохиолдолд нийгмийн харилцааны ажилтан мэдээ тараахдаа хор хөнөөл учруулах тодорхой зорилготой байсан, худал мэдээ тарааж байгаагаа бүрэн мэдэж байсан, эсвэл ийм мэдээний үнэн, худлыг тогтооход хайхрамжгүй хандсан нь нотлогдох ёстой.⁸⁴

⁸¹ *New York Times Company v. Sullivan*, 376 U.S. 254 (1964), <https://www.law.cornell.edu/supremecourt/text/376/254>.

⁸² Kyu Ho Youm describes this in Argentina, Bosnia-Herzegovina, Hungary, India, the Philippines, and Taiwan, for example. Kyu Ho Youm, "The 'Actual Malice' of *New York Times Co. v. Sullivan*: A Free Speech Touchstone in a Global Century", 19 *Communication Law and Policy* 185 (2014).

⁸³ *Ibid.*

⁸⁴ Adopted 19 October 2000, Principle 10, <https://www.cidh.oas.org/declaration.htm>.



Хүний эрхийн хороо мөн “шүүмжлэлийн сэдэв олон нийтийн сонирхлыг татсан нь хамгаалалт болно гэж хүлээн зөвшөөрөх ёстой” гэж тэмдэглэжээ.⁸⁵ Хэлсэн үг олон нийтийн хууль ёсны ашиг сонирхлын асуудалд хамаатай тохиолдолд гүтгэлгийн хариуцлага нь үг хэлэх эрх чөлөөнд харьцуулшгүй дарамт учруулах магадлал өндөр байдаг, учир нь энэ нь илтгэгчийн амыг барихаас гадна олон нийтийн ач холбогдолтой асуудлын талаар илүү өргөн хүрээтэй хэлэлцүүлэг өрнүүлж, мэдээлэл олж авахад саад учруулах эрсдэлтэй.

Эцэст нь, дижитал эрин үед гүтгэлгийн тухай дүрэм журамтай холбоотойгоор шинэ асуудлууд гарч ирж байна. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний ерөнхий стандарт нь контентын ямар ч төрлийн хязгаарлалтын нэгэн адил онлайнаар гүтгэх асуудалд мөн хамаарна.⁸⁶ Жишээлбэл, “цахим гүтгэлэг”-ийн тусгай хууль гаргах нь тийм ч зохимжтой биш, учир нь хүмүүс үгээ онлайнаар хэллээ гэж улс орнууд контентын шинэ хязгаарлалт, стандартыг бий болгох ёсгүй. Гэвч онлайн гүтгэлэгтэй холбоотойгоор зарим онцгой асуудал гарч ирдэг. Жишээ нь:

- Зөвлөмж болгож буй илүү сайн туршлага бол “ганц нийтлэлийн дүрэм” юм. Энэ нь хөөн хэлэлцэх хугацаа тогтоох зорилгоор контентыг интернэтэд нийтэлсэн анхны тохиолдлыг л тооцох ба хохирлыг барагдуулах нэг л нэхэмжлэл гаргахыг зөвшөөрдөг.⁸⁷ Интернэтийн эрин үед олон нийтлэлийн дүрэм нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэвлэн нийтлэгчийг үндсэндээ эцэс төгсгөлгүй хариуцлага хүлээхэд хүргэх болно.
- Дижитал эрин үе нь өөрт тохирох шүүхийг хайх (“forum shopping”), “гүтгэлгийн аялал жуулчлал”-ын (“libel tourism”) асуудлыг ихээхэн хурцатгаж, гүтгэлгийн хэрэг үүсгэсэн хүмүүс өөрсдийн нэхэмжлэлд хамгийн таатай харьяаллыг зүй бусаар сонгодог болжээ. Энэ нь “хамгийн бага ерөнхий хуваарь” (“lowest common denominator”) гэх хандлагыг бий болгосноор үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд

⁸⁵ General Comment No. 34, note 43, para. 47. See also UN Special Rapporteur on freedom of expression, *Reinforcing media freedom and the safety of journalists in the digital age*, 20 April 2022, para. 113, undocs.org/A/HRC/50/29; and *Report of the Special Rapporteur on the promotion and protection of the right to freedom of opinion and expression*, 6 September 2016, para 34, undocs.org/A/71/373

⁸⁶ For a very introductory discussion, see CLD, *Model Training Materials: Overview of Freedom of Expression under International Law*, October 2022, https://www.law-democracy.org/live/wp-content/uploads/2022/12/Training-Materials-1.FOE_format-1.pdf.

⁸⁷ Special international mandates on freedom of expression, 2011 Joint Declaration on Freedom of Expression and the Internet, para. 4(c), <https://bit.ly/3DJaNaB>; and Agnes Callamard, *Global Trends in Freedom of Expression Jurisprudence in 2014*, 10-11 March 2015, <https://bit.ly/3UfubDi>.



муугаар нөлөөлнө.⁸⁸ Улс орнууд өөрсдийн дотоод шүүх эрх мэдлийн дүрэмдээ өөрчлөлт оруулах замаар ийм практикийг багасгахын тулд талууд зөвхөн их хэмжээний хохирол амссан харьяаллын дагуу шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой байх талаар бодож үзэх хэрэгтэй.⁸⁹

Төрийн албан хаагчид, улс төрчид

Зарим улс оронд төрийн тэргүүн болон бусад төрийн албан тушаалтныг доромжлох, гүтгэхээс хамгаалсан тусгай хууль журамтай байдаг эсвэл тийм түүхэн уламжлалтай байсан байдаг. "Лез мажестэ" ("lèse majesté") гэгдэх хуульд эзэн хааныг шүүмжлэхийг хориглодог бол *десакато* (desacato) хуулиар төрийн тэргүүн, улс төрчид, төрийн албан хаагчдыг тусгай хамгаалалтад авдаг.

Төрийн зүтгэлтний ийм төрлийн тусгай хамгаалалт нь олон нийтийн ашиг сонирхлын талаарх үг яриаг зохицуулдаг олон улсын хуулийн стандартыг зөрчиж байна. Хүний эрхийн хорооноос мэдэгдсэнээр "улс төрийн хүрээний нийгмийн зүтгэлтэн болон олон нийтийн байгууллагын талаар олон нийтийн мэтгэлцээн өрнөж байгаа нөхцөлд Пактын дагуу үзэл бодлоо саадгүй илэрхийлэх нь онцгой үнэ цэнтэй юм".⁹⁰ Жирийн хүнтэй харьцуулахад нийгмийн зүтгэлтнүүдийг тусгайлан хамгаалаад байх ёсгүй юм, учир нь тэдний үйлдэл нь нийгэмд илүү өргөн хүрээнд нөлөөлөх боломжтой.

Иймээс төрийн албан тушаалтныг доромжилсон этгээдэд хариуцлага тооцдог хууль хүчин төгөлдөр бус юм. Ийм хүмүүст гүтгэлгийн хэргээр илүү хатуу шийтгэл оногдуулах нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг мөн адил зөрчиж байна.⁹¹ Энэ зарчим нь бүс нутгийн хүний эрхийн шүүхийн хууль зүйд баттай суусан байдаг.

⁸⁸ Special international mandates on freedom of expression, 2020 Joint Declaration on Freedom of Expression and Elections in the Digital Age, para 9(d), <https://bit.ly/3NFVhRu>. See also UN Special Rapporteur on freedom of expression, *Reinforcing media freedom and the safety of journalists in the digital age*, note 85, para. 113.

⁸⁹ 2011 Joint Declaration on Freedom of Expression and the Internet, note 87, para. 4(a); and Committee of Ministers of the Council of Europe, Declaration on the Desirability of International Standards dealing with Forum Shopping in respect of Defamation ("Libel Tourism"), 20 July 2012, para. 9 (citing to the 2011 Joint Declaration).

⁹⁰ General Comment No. 34, note 43, para. 38.

⁹¹ General Comment No. 34, note 43, para. 38; 2021 Joint Declaration on Politicians and Public Officials and Freedom of Expression, note 35, para. 2(b)(iii); Inter-American Declaration of Principles on Freedom of Expression, note 84, Principle 11; and Committee of Ministers of the Council of Europe, Declaration on freedom of political debate in the media, 12 February 2004, para. VI, <https://bit.ly/3fGBJju>.



Европын Хүний эрхийн шүүх төрийн албан тушаалтан эсвэл эзэн хаан⁹², төрийн тэргүүн⁹³, гадаадын төрийн тэргүүн зэрэг удирдагчдын тусгай хамгаалалтад үндэслэсэн гүтгэлгийн хэргийн ял шийтгэлийг удаа дараа хүчингүй гэж үзэж байсан.⁹⁴ Америк хоорондын хүний эрхийн шүүх ч мөн адил төрийн албан тушаалтан, улс төрчдөд зориулсан тусгай хамгаалалтыг хүчингүй гэж үзсэн⁹⁵, харин Африкийн хүний болон ард түмний эрхийн шүүхээс нийгмийн зүтгэлтний нэр хүндийн талаарх хуулиар жирийн хүнд хамаардаг хуулиас "илүү хатуу шийтгэл" оногдуулах ёсгүй гэж мэдэгджээ.⁹⁶ Гүтгэлгийн хэргийг шийдвэрлэж буй шүүх нь төрийн албан тушаалтныг тусгай хамгаалалтад авахын оронд төрийн албан тушаалтнуудын үйлдлийн талаар олон нийтээр хэлэлцүүлэхийг зөвшөөрөхийн чухлыг анхаарч үзэх хэрэгтэй.

Хүний эрхийн шүүхүүд гүтгэлгийн хэрэгт хатуу шийтгэл оногдуулах нь шаардлагагүй эсвэл зохистой бус шийтгэл гэж тогтоох нь их байдаг, ялангуяа хэлсэн үг олон нийтийн ашиг сонирхлын асуудалтай холбоотой, илтгэлийн бай нь төрийн албан тушаалтан байх тохиолдолд ийм шийдвэр бүр ч хамаатай байдаг. Эдгээр шүүх энэ хандлагыг илүү өргөтгөн олон нийтийн хараа хяналтад өөрөө өртсөн нийгмийн зүтгэлтэнд, эсвэл хэлэлцэж буй асуудал олон нийтийн анхаарлыг ихээр татсан үед хэрэглэсэн. Жишээлбэл, Америк хоорондын шүүх дараах зүйлийг дурдав:

хамгаалалтын өөр босго ... төрийн албан тушаалтан, нийтийн шинж чанартай чиг үүргийг хэрэгжүүлэгч хувь хүн, улс төрчдийн хувьд хамгаалалтын өөр босго хэрэглэх ёстой, энэ нь субъектийн шинж чанарт бус, харин тодорхой хувь хүний үйл ажиллагаа, үйлдэлд шингэсэн байдаг олон нийтийн ашиг сонирхлын шинж чанарт тулгуурласан байх ёстой.

Олон нийтийн ашиг сонирхлын асуудалд нөлөө үзүүлдэг хүмүүс өөрсдөө сайн дураараа олон нийтийн хяналтад орж илүү нээлттэй байдгийн улмаас энэ салбарт шүүмжлэлд өртөх эрсдэл өндөр байдаг. Учир нь тэдний үйл ажиллагаа хувийн хүрээнээс хальж, олон нийтийн мэтгэлцээний хүрээнд хамаарна.⁹⁷

Эцэст нь хэлэхэд төрийн албан тушаалтан, улс төрчдийг гүтгэхээс хамгаалсан гүтгэлгийн гэмт хэргийн тухай хууль нь ялангуяа зохисгүй гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Жишээлбэл, Америк хоорондын Хүний эрхийн шүүх өмнө дурдсанчлан гүтгэлгийг эрүүгийн хуулиар шийдэх явдлыг эцэслэн халаагүй ч саяхны хоёр хэрэг дээр олон нийтийн ашиг сонирхлын асуудлаарх мэтгэлцээний хүрээнд төрийн албан тушаалтны нэр төрийг хамгаалах арга хэрэгсэл болгож гүтгэлгийг эрүүгийн хуулиар

⁹² *Otegi Mondragon v. Spain*, 15 March 2011, Application No. 2034/07, <https://bit.ly/3E95Cm1>.

⁹³ *Artun and Güvener v. Turkey*, Application No. 75510/01, 26 June 2007, <https://bit.ly/3TgMwyl>.

⁹⁴ *Colombani and Ors v. France*, note 69.

⁹⁵ See, for example, *Tristán Donoso v. Panama*, 27 January 2009, Series C, No. 193 (Inter-American Court of Human Rights), <https://bit.ly/3UqE5By>; and *Kimel v. Argentina*, note 56.

⁹⁶ *Lohé Issa Konaté v. Burkina Faso*, note 58, paras. 155-156.

⁹⁷ *Ricardo Canese v. Paraguay*, 31 August 2004, Series C, No. 111, para. 103, <https://bit.ly/3E5N1Hb>.

шийдэх нь хэзээд зохистой зүйл биш гэдгийг тодорхой мэдэгдсэн.⁹⁸

Олон нийтийн оролцооны эсрэг стратегийн нэхэмжлэл (SLAPP)

Олон нийтийн оролцооны эсрэг стратегийн нэхэмжлэл (ОНОЭСН) буюу SLAPP (strategic litigation against public participation) нь олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн асуудлаарх үг яриаг чимээгүй болгох зорилготой дарамт шахалтын эсвэл хариу арга хэмжээ авах нэхэмжлэл юм. Ийм нэхэмжлэл нь ихэвчлэн хууль эрх зүйн үндэслэлгүй бөгөөд эсрэг талд шүүхийн зардал, хүндрэл учруулж залхаах зорилготой байдаг. Ийм нэхэмжлэлтэй тэмцэх хөрөнгө мөнгөний хомсдолтой сэтгүүлч, ашгийн бус байгууллага, хувь хүмүүс зүгээр л тохиролцоо хийх, эсвэл асуудлын талаар мэдээлэхээ зогсоож (энэ нь өөртөө цензур тогтоох нэг хэлбэр мөн) болно. Жишээлбэл, сэтгүүлчид ОНОЭСН гаргадгаараа нэртэй корпорацуудын хууль бус үйлдлийн талаар мэдээлэхээс зайлсхийж мэдэх юм.

ОНОЭСН-ийн эсрэг хууль нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дарахын тулд хуулийн тогтолцоог урвуулан ашиглах явдлыг хязгаарлах зорилготой бөгөөд үүнийг голчлон хэргийг хурдан шийдвэрлэх арга зам бий болгосноор шийдвэрлэдэг. Гүтгэлгийн тухай хуулийг ашиглан ОНОЭСН-ийг урвуулан ашиглах нь их байдаг ч ОНОЭСН-ийг өөр шалтгаанд үндэслэн гаргаж болох тул ОНОЭСН-ийн эсрэг хууль нь яг гүтгэлгийн хэрэгт холбоотой хууль биш юм. Уг хууль нь дараах шинж чанарыг агуулж болно:

- Хэргийг хугацаанаас нь өмнө хэрэгсэхгүй болгох боломжтой байх. Үүнийг хариуцагч хүсэлт гаргаснаар хэрэгжүүлэх, эсвэл зарим улсад шүүх өөрөө ОНОЭСН-ийг хэрэгсэхгүй болгох эрхтэй байж болно.
- Шүүхийн зардлыг, тэр дундаа өмгөөлөгчийн хөлсийг оролцуулан хариуцагчид нөхөн олгох боломжтой байх, ялангуяа энэ зардлыг ялагдсан тал нь төлдөггүй улс орнуудад.
- ОНОЭСН гаргахаас сэргийлэх торгууль, ялангуяа ОНОЭСН-ийг хэрэгсэхгүй болгосны торгууль ногдуулах гэх мэт
- ОНОЭСН-д хариуцагчаар татагдсан хүмүүст хууль зүйн туслалцаа үзүүлэх эсвэл тэдэнд дэмжлэг үзүүлэх тусгай сан байгуулах зэрэг бусад арга хэмжээ

Олон улсын хүний эрхийн хуулийн стандартаар улс орнууд ОНОЭСН-ийн эсрэг дүрэм журам гаргах, эсвэл өөр төстэй арга хэмжээ авах эерэг үүрэг хүлээхийг санал болгож байна. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний төлөө тусгай мандатууд 2021 оны хамтарсан тунхаглалдаа улс орнуудад дараах уриалгыг гаргав:

⁹⁸ *Urrutia v. Ecuador*, 24 November 2021, Series C, No. 446, paras. 117-120, 127, <https://bit.ly/3FU4Z0L>; *Alvarez Ramos v. Venezuela*, 30 August 2019, Series C, No. 380, paras. 121-123, 129, <https://bit.ly/3DExpt3>.

Нийтийн ашиг сонирхлын асуудлаар хийсэн мэдэгдэлтэй холбоотой, амжилтад хүрэх бодит боломжгүй, гүтгэлгийн эсрэг нэхэмжлэлийг шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эхний шатанд шүүгдэгчийн хүсэлтээр эсвэл өөрийн санаачилгаар хэргийг хялбарчилсан байдлаар хэрэгсэхгүй болгох эрхтэй байхыг хангах.⁹⁹

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгчид бусад үед мөн ОНОЭСН-ийн эсрэг хууль тогтоомж эсвэл холбогдох арга хэмжээг, тухайлбал, ОНОЭСН-ийн бай болсон хүмүүст эрх зүйн дэмжлэг үзүүлэхийг дэмжиж байгаагаа илэрхийлсэн.¹⁰⁰ Цаашилбал, 2021 онд *Паласио Уррутия Эквадорын эсрэг* шүүх хурлаар гаргасан шийдвэртээ Америк хоорондын хүний эрхийн шүүх дараах зүйлийг дурджээ:

Төрийн албан тушаалтнууд гүтгэлэг, доромжлолын хэргээр шүүхийн шугамаар гомдол гаргах нь ахин дахин давтагдаж байгаа нь, ингэхдээ байдлыг засаж залруулах зорилгоор бус, харин тэдний олон нийтийн дунд явуулж буй үйл ажиллагаатай холбоотой шүүмжлэлийг дарах зорилготой байгаа нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд заналхийлж байна гэж шүүх үзэж байна. "ОНОЭСН - Олон нийтийн оролцооны эсрэг стратегийн нэхэмжлэл" (SLAPP) гэж нэрлэгддэг энэ төрлийн үйл явц нь шүүхийн механизмыг урвуулан ашиглах явдал бөгөөд, үүнийг улс орнууд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор зохицуулж, хянаж байх ёстой юм.¹⁰¹

2022 онд Европын хүний эрхийн шүүх төрийн байгууллагын гаргасан зүй бус нэхэмжлэлтэй холбоотойгоор холбогдох хууль тогтоомжийг хянахдаа ОНОЭСН-ий тухай ч мөн тодорхой дурджээ.¹⁰² Үүнээс өмнөх хэргүүд дээр ч яг энэ нэр томъёог ашиглаагүй ч ОНОЭСН-тэй төстэй нэхэмжлэлийг хэлэлцэхээс татгалзаж байсан байдаг. Жишээлбэл, *Стил ба Моррис-ийн Нэгдсэн Вант улсын эсрэг* шүүх хурал дээр Макдоналдсын эсрэг сурталчилгаа тараасан хоёр идэвхтний эсрэг Макдоналдсын гаргасан нэхэмжлэлийг шүүх авч үзсэн. Шүүхээс идэвхтнүүдэд оногдуулсан их хэмжээний торгууль, идэвхтнүүд болон корпорацын эрх мэдлийн тэгш бус байдал, мөн идэвхтнүүдэд хууль зүйн туслалцаа үзүүлээгүй байдал зэрэг нь шударга шүүхээр шүүлгэх, үг хэлэх эрх чөлөөг нь зөрчсөн байна гэж үзжээ.¹⁰³

⁹⁹ 2021 Joint Declaration on Politicians and Public Officials and Freedom of Expression, note 35.

¹⁰⁰ UN Special Rapporteur on freedom of expression, *Reinforcing media freedom and the safety of journalists in the digital age*, note 85, para. 113; UN Special Rapporteur on the Rights to Freedom of Peaceful Assembly and of Association, *Info Note, SLAPPs and FoAA Rights*, 2017, <https://bit.ly/3Tbgu74>; and UN Working Group on Business and Human Rights, *Guidance on National Action Plans on Business and Human Rights*, December 2014, p. 37.

¹⁰¹ *Urrutia v. Ecuador*, note 98, para. 95.

¹⁰² *ООО Memo v. Russia*, 15 March 2022, Application No. 2840/10, para. 23, <https://bit.ly/3t2UFfh>.

¹⁰³ *Steel and Morris v. United Kingdom*, 15 May 2005, Application No. 6846/01, <https://bit.ly/3UdXCpc>.



Улс орнууд ОНОЭСН-ийн эсрэг хуулийг сонирхох нь ихсэж байгаа ч ийм хууль харьцангуй цөөн хэдэн улсад л батлагдсан байдаг. АНУ, Канад, Австралийн муж улс, мужууд ОНОЭСН-ийн эсрэг хуультай боловч дэлхий даяар ийм хууль дутагдалтай байна. Гэхдээ Европт нөхцөл байдал өөрчлөгдөх хандлагатай байгаа ба Европын Комиссоос ОНОЭСН-ийн талаар зөвлөмж болон удирдамжийн төслийг боловсруулсан юм.¹⁰⁴ Ерөнхийдөө, НҮБ-ын Тусгай илтгэгчийн дурдсанаар, дэлхийн хэмжээнд сэтгүүлчдийг дарамтлах зорилгоор шүүхийн тогтолцоог урвуулан ашиглах асуудлыг шийдвэрлэхийн тулд "улс орнууд илүү ихийг хийх шаардлагатай байна".¹⁰⁵ Мөн өөр өөр нөхцөл байдалд ОНОЭСН гаргах явдалтай тэмцэх шилдэг стратегийн талаар илүү их хэлэлцүүлэг өрнүүлэх шаардлагатай байна.

ОНОЭСН-ийн эсрэг хууль тогтоомжийг анхааралтай боловсруулах ёстой. Эдгээр хууль тогтоомж нь анх тавьсан зорилгодоо хүрэх, шударга шүүхээр шүүлгэх эрхийг зүй бусаар зөрчихөөс зайлсхийх, буруу санаа өвөрлөсөн шинэ хэлбэрийн үйлдэл гарахаас сэргийлэхэд анхаарсан байх ёстой. Олон нийтийн эрх ашгийн төлөө үг хэлэх гэдгийг хэрхэн тодорхойлох, шүүх ямар үндэслэлээр нэхэмжлэлийг эрт хэрэгсэхгүй болгох вэ гэдэгтэй холбоотойгоор хэцүү асуултууд гарч ирдэг. Цаашилбал, нөхцөл байдлаас шалтгаалан гүтгэлгийн хуулийг урвуулан ашиглахтай тэмцэхэд дээр дурдсан төрлийн ОНОЭСН-ийн эсрэг хууль нь хамгийн үр дүнтэй стратеги биш байж ч болох юм. Жишээ нь, сэтгүүлч, идэвхтнүүд юм л бол гүтгэлгийн гэмт хэрэгт унаж байгаа үед гүтгэлгийг гэмт хэрэг гэж үзэхгүй байх нь нэн тэргүүний зорилт байж болох юм. Эдгээрийг үл харгалзсан ч ОНОЭСН-ийн эсрэг арга хэмжээ нь олон улс оронд гүтгэлгийн эсрэг нэхэмжлэлийг урвуулан ашиглахаас хамгаалах чухал шинэлэг санаа байж болох юм.

¹⁰¹ *Urrutia v. Ecuador*, note 98, para. 95.

¹⁰² *ООО Memo v. Russia*, 15 March 2022, Application No. 2840/10, para. 23, <https://bit.ly/3t2UFfh>.

¹⁰³ *Steel and Morris v. United Kingdom*, 15 May 2005, Application No. 6846/01, <https://bit.ly/3UdXCpc>.

¹⁰⁴ Proposal for a Directive of the European Parliament and of the Council on protecting persons who engage in public participation from manifestly unfounded or abusive court proceedings ("Strategic lawsuits against public participation"), COM/2022/177 final, 27 April 2022, <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A52022PC0177>.

¹⁰⁵ UN Special Rapporteur on freedom of expression, *Reinforcing media freedom and the safety of journalists in the digital age*, note 85, para. 69.



ОНОЭСН-ийн эсрэг хууль

Калифорни (Америкийн Нэгдсэн Улс): ОНОЭСН-ийн эсрэг хамгаалалт 1992 оноос хойш хэрэгжиж байгаа Калифорни муж улсын ОНОЭСН-ийн эсрэг хууль нь илүү өргөн хүрээг хамарсан хуулиудын нэг юм. Энэ хууль нь дараах онцлог шинжийг агуулдаг:

- Нэхэмжлэгч олон нийтийн асуудлаар өргөдөл гаргах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ хэрэгжүүлэх үндэслэлээр нэхэмжлэл гаргасан бол шүүгдэгч хэргийг хэлэлцэхээс татгалзах тухай тусгай хүсэлт гаргаж болно. Нэхэмжлэл нь олон нийтийн асуудлаар хэлсэн үгэнд үндэслэсэн бол нэхэмжлэгч уг хэрэг дээр давамгайлах магадлалаа нотолж чадахгүй бол шүүх хэргийг авч хэлэлцэхгүй.¹⁰⁶
- АНУ-д "нээлт" ("discovery") гэж нэрлэгддэг, талууд бие биенээсээ нотлох баримт цуглуулах ажиллагааг (ихэвчлэн өндөр өртөгтэй байдаг) хэрэв шүүхээс тусгайлан "нээлт" явуулах шийдвэр гаргаагүй л бол, шүүх хүсэлтийг хэлэлцэх үед "нээлт"-ийг түр зогсоодог.¹⁰⁷
- Хэрэв хариуцагчийн тусгай хүсэлт амжилттайгаар шийдэгдсэн бол шүүх нэхэмжлэгчээс өмгөөлөгчийн хөлс, бусад зардлыг хариуцахыг шаардана (АНУ-д талууд өөр өөрийн зардлыг хариуцах нь хэвийн зүйл юм). Эсрэгээр, нэхэмжлэгч хариуцагчийн нэхэмжлэл хэлэлцэхгүй байх тусгай хүсэлт үндэслэлгүй, эсвэл зөвхөн саатуулах зорилготой байсныг нотолсон бол нэхэмжлэгч төлбөр, зардлыг хариуцагчаас гаргуулж болно.¹⁰⁸
- Нэхэмжлэл хэлэлцэхгүй байх тухай хүсэлтийн талаарх шүүхийн шийдвэрийг талууд нэн даруй давж заалдах боломжтой.¹⁰⁹
- Дараа нь уг хуулийг урвуулан ашиглахаас сэргийлэх асуудлыг тодорхойлж нэмэлт өөрчлөлт оруулсан. Нийтийн ашиг сонирхлын төлөө хариуцлагаас чөлөөлөх зарчим (public interest exemption) нь ашгийн бус нэхэмжлэгч нийтийн ашиг сонирхлын маргаан үүсгэсэн тохиолдолд уг журмыг хэрэгжүүлэхээс үр дүнтэй сэргийлж байна. Арилжааны үг хэллэгээс чөлөөлөх зарчмаар (commercial speech exemption) худал сурталчилгаатай холбоотойгоор шүүхэд хамтарсан гомдол гаргасан тохиолдолд хариуцагч корпорац ОНОЭСН-ийн эсрэг хуулийг ашиглахыг хязгаарладаг.¹¹⁰

¹⁰⁶ California Code of Civil Procedure, section 425.16(b),(e), <https://bit.ly/3Tf4a5E>.

¹⁰⁷ *Ibid.*, section 425.16(g). ¹⁰⁸ *Ibid.*, section 425.16(c). ¹⁰⁹ *Ibid.*, section 425.16(i).

¹⁰⁸ *Ibid.*, section 425.16(c).

¹⁰⁹ *Ibid.*, section 425.16(i).

¹¹⁰ *Ibid.*, section 425.17; for a discussion of the exemptions (narrowed by the California Supreme Court) see Julio Sharp-Wasserman, "New York's Anti-SLAPP Law is Only a Slap on the Wrist", *NYSBA Journal*, 2019, <https://bit.ly/3UcrRNo>.

- ОНОЭСН-ийн эсрэг зарим хуулиас ялгаатай нь шүүхэд торгууль ногдуулах боломж байхгүй. Гэвч, Калифорни муж улс нь хэрэг шийтгэх хөнгөвчилсэн тусгай журам тогтоож, ОНОЭСН-ийн эсрэг сөрөг нэхэмжлэл (“SLAPP-back” countersuit) гаргах журмыг хөнгөвчилсэн, өөрөөр хэлбэл, энэ нь ОНОЭСН-ийг анх гаргасан талын эсрэг ОНОЭСН-ийн бай болсон талаас гаргасан яллах нэхэмжлэл юм.¹¹¹

Филиппин: Филиппин нь байгаль орчны салбарт ОНОЭСН-ийн эсрэг хязгаарлагдмал хамгаалалт тогтоосон байдаг. Үүнтэй холбоотой журмыг хууль тогтоох байгууллага тогтоогоогүй, харин Дээд шүүхээс 2010 онд олон талт хэлэлцүүлгийн үр дүнд Байгаль орчны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журамдаа тусгасныг онцлон тэмдэглэх нь зүйтэй.¹¹²

Уг журмаар хуулийн арга хэмжээг байгаль орчны хууль тогтоомж, эрхтэй холбоотойгоор "айлган сүрдүүлэх, залхаах, зүй бус шахалт үзүүлэх, хууль эрх зүйн аливаа арга хэмжээг боогдуулах" зорилгоор авсан тохиолдолд ОНОЭСН-ийн хамгаалалт тогтоодог. Хэрэв иргэний нэхэмжлэлтэй хариуцагч нэхэмжлэлийг ОНОЭСН гэж үзэж байгаа бол хураангуй хуралдааныг эхлүүлэх ба хариуцагч өөрийн үйл ажиллагаа нь байгаль орчныг хамгаалах тал дээр хууль ёсны байсан гэдгийг дорвитой баримтаар нотлох ёстой, харин нэхэмжлэгч үйлдэл нь ОНОЭСН биш, хүчин төгөлдөр нэхэмжлэл гэдгийг нотлох баримтын давуу байдлаар нотлох ёстой. Хуралдааны үндсэн дээр шүүх хэргийг дахин нэхэмжлэх эрхгүйгээр хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргаж болно (дараа нь дахин нэхэмжлэх боломжгүй гэсэн үг). Мөн хариуцагч хохирлоо барагдуулах, өмгөөлөгчийн хөлс, зардлаа нэхэмжилж сөрөг нэхэмжлэл гаргах боломжтой.¹¹³ ОНОЭСН-ийн хамгаалалт эрүүгийн хэрэгт ч байдаг бөгөөд иргэний нэхэмжлэлийн нэгэн адил нотолгоо шаардсан хураангуй хуралдаан явуулдаг боловч, эрүүгийн хэргийн хувьд яллагдагч хэргийг айлган сүрдүүлэх, залхаах, зүй бус шахалт үзүүлэх, хууль ёсны арга хэмжээ авахыг боомилох зорилгоор үүсгэсэн гэж нотолж чадвал шүүгч хэргийг хэрэгсэхгүй болгодог.¹¹⁴

¹¹¹ *Ibid.*, section 425.18.

¹¹² Rationale to the Rules of Procedure for Environmental Cases, April 2010, pp. 96-97, <https://bit.ly/3UdEdVp>.

¹¹³ Supreme Court of the Philippines, Rules of Procedure for Environmental Cases, A.M. No. 09-6-8-SC, 13 April 2010, Rule 6, <https://bit.ly/3zSjP4e>.

¹¹⁴ *Ibid.*, Rule 19





The Centre for Law and Democracy is a non-profit human rights organisation working internationally to provide legal expertise on foundational rights for democracy.

